

## ХОВД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСЭЭС 2021 ОНД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.11.17

Тус хэлтсээс тайлант онд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нилээд ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хэлтсийн эцэг эхийн зөвлөлийг байгуулж, байгууллагын ажилтнуудын дунд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр аймгийн Хүүхэд залуучуудын газартай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулж 8-10, 11-13, 14-16 насны хүүхдүүдийн дунд “хүүхэд миний эрх” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулан ажиллаа.

Мөн эцэг эхийн зөвлөл аймгийн Хүүхэд залуучуудын газраас зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг” сургалт, Хүүхэд хамгааллын сургалтанд хамрагдаж байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааныхаа талаар тус сургалтанд хамрагдсан иргэдэд мэдээлэл хийсэн.



Хүүхэд хамгааллын чиглэлээр Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн сурагчдад аймгийн Цагдаагийн газар, Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран сургалт зохион байгуулж ажилласан.



Мөн шинээр гэрлэлтээ батлуулж буй залуу гэр бүлд анхан шатны нэгж дээр ажиллаж буй улсын бүртгэгч нар “Гэр бүлийн тухай хууль”-иар 15 минутын мэдээлэл хийж хэвшсэн.



Жаргалант сумын 12 багийн Нийгмийн ажилтнуудтай хамтран тус хэлтсийн эцэг эхийн зөвлөл зорилтот бүлгийн 16 айлаар явж, гэр бүлийн тухай хуулиар тухайн гэр бүлүүдэд мэдээлэл хийж, гээж үрэгдүүлсэн бичиг баримтаа хэрхэн яаж авах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

ХОВД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС